



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 09 өдөр

Дугаар A/294

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.6 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан "Аймгийн шагналын журам"-ын 1.2.9, 3.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Эрдэнэбүрэн суманд зохион байгуулагдах "Дунд үеийнхний чуулга уулзалт"-ыг тохиолдуулан сум, орон нутгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх, мал аж ахуйн салбарт гаргасан амжилт бүтээлийг үнэлж нэр бүхий иргэдийг аймгийн Засаг даргын Хүндэт өргөмжлөлөөр шагнахад 120000 төгрөгийг хавсралтаар баталж, зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 120000 төгрөг /Нэг зуун хорин мянган/-ийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

02-01449

Аймгийн Засаг даргын 2019 оны
05 дугаар сарын 09-ний өдрийн
А/294 дүгээр захирамжийн хавсралт



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН “ХҮНДЭТ ӨРГӨМЖЛӨЛ”-ӨӨР
ШАГНАГДАХ ХҮМҮҮСИЙН НЭРС

№	Овог нэр	Эрхэлж буй ажил, албан тушаал	Арга хэмжээ	Олгох шагнал
1	Ч.Хашбаатар	Эрдэнэбүрэн сумын Шураг багийн малчин	Дунд үеийнхний чуулга уулзалт	30000
2	Ч.Ширэндэв	Эрдэнэбүрэн сумын Шураг багийн малчин	Дунд үеийнхний чуулга уулзалт	30000
3	Т.Бямбасүрэн	Эрдэнэбүрэн сумын Баянгол багийн малчин	Дунд үеийнхний чуулга уулзалт	30000
4	Э.Сумъяа	Эрдэнэбүрэн сумын Намаржин багийн малчин	Дунд үеийнхний чуулга уулзалт	30000
Дүн				120000